



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 5/45

Улаанбаатар хот

Сайдын зөвлөлийн гишүүдэд урамшуулал  
олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын “Журам батлах тухай” 1996 оны 259 дүгээр тогтоолоор батлагдсан “Сайдын зөвлөлийн ажиллах нийтлэг журам”-ын 5 дахь заалт, “Журам батлах тухай” Сангийн сайдын 1997 оны 176 дугаар тушаалаар баталсан “Сайдын зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох, түүний эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах журам”, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Сангийн сайдын 2006 оны 112 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн гишүүд болон нарийн бичгийн даргад олгох 2021 оны урамшууллын хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Сайдын зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн даргын урамшууллыг хавсралтад заасны дагуу тооцож олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Ренчиндамба)-т зөвшөөрсүгэй.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

С.БАТБОЛД



080000298